



ШҮҮХИЙН СУРГАЛТ,
СУДАЛГАА,
МЭДЭЭЛЛИЙН ХҮРЭЭЛЭН

**ЭРҮҮГИЙН ХЭРГИЙН УЛМААС УЧИРСАН ХОХИРОЛ ГЭХ
ХҮҮ, НЭМЭГДҮҮЛСЭН ХҮҮГ ОЛОХ БАЙСАН ОРЛОГОД
ТООЦОН ХОХИРОЛ НЭХЭМЖЛЭХ**

СУДАЛГААНЫ САН: ИХ/00/2021/02/04

УЛААНБААТАР
2021.10.27

**ЭРҮҮГИЙН ХЭРГИЙН УЛМААС УЧИРСАН ХОХИРОЛ ГЭХ ХҮҮ, НЭМЭГДҮҮЛСЭН ХҮҮГ
ОЛОХ БАЙСАН ОРЛОГОД ТООЦОН ХОХИРОЛ НЭХЭМЖИЛЖ БҮЙ МАРГААН**



ТОВЬЁГ

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ	3
НЭГ. ГЭМТ ХЭРГИЙН УЛМААС УЧИРСАН ХОХИРЛЫГ	5
ИРГЭНИЙ ЖУРМААР НЭХЭМЖЛЭХ	5
ХОЁР. БАНКНЫ ХҮҮ, НЭМЭГДҮҮЛСЭН ХҮҮГ	7
ОЛОХ БАЙСАН ОРЛОГОД ТООЦОХ	7
ГУРАВ. КОМПАНИЙН ХАРИУЦЛАГЫН ОНОЛЫН ОЙЛГОЛТ,	7
ГАДААД УЛСЫН ТУРШЛАГА	7
ДӨРӨВ. ШҮҮХИЙН ПРАКТИК	17
ТАВ. ДҮГНЭЛТ	19
ЗУРГАА. ЭХ СУРВАЛЖ	20



ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

АНУ	Америкийн Нэгдсэн Улс
АШШ	Анхан шатны шүүх
ИХ	Иргэний хууль
ИХШХШТХ	Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль
УДШ	Улсын дээд шүүх
НИХДЗШШ	Нийслэлийн иргэний хэргийн давж заалдах шатны шүүх
ОХУ	Оросын Холбооны Улс
ЭХХШТХ	Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль
ЭХ	Эрүүгийн хууль



УДИРТГАЛ

Судлах зүйл

1. Эрүүгийн хэргийн улмаас учирсан хохирол гэх хүү, нэмэгдүүлсэн хүүг олох байсан орлогод тооцон хохирол нэхэмжлэх болон компанийн гүйцэтгэх удирдлагын гуравдагч этгээдэд учруулсан гэм хорыг компани хариуцан арилгах эрх зүйн үндэслэлийн асуудлаар Монгол Улсын шүүхийн практик, бусад улсын туршлагыг судлав.

Судалгааны зорилго

2. Судалгааны ажлын зорилго нь судлах зүйлтэй холбоотой Монгол Улсын шүүхийн шийдвэрүүдэд хайлт хийн ижил төстэй шүүхийн шийдвэрийг олж судлах, онол ойлголт, бусад улсын төстэй зохицуулалт, туршлагыг харьцуулан дүн шинжилгээ хийхэд оршино. Судалгааны зорилгын хүрээнд дараах асуудлуудыг хөндөж, дүн шинжилгээ хийв:
 1. Иргэний хэргийн шүүхийн төстэй шийдвэрт хайлт хийх, түүнд дүн шинжилгээ хийх;
 2. Онолын ойлголтыг судлах;
 3. Бусад улсын эрх зүйн зохицуулалт, туршлагыг харьцуулан авч үзэх;
 4. Компанийн эрх бүхий этгээдийн гэм буруу компанийн хариуцлагад нөлөөлөх эсэхтэй холбоотой онолын ойлголтыг судлах;
 5. Компанийн эрх бүхий этгээдийн гэм буруу компанийн хариуцлагад нөлөөлөх эсэхтэй холбоотой бусад улсын туршлага судлах, өөрийн улсын эрх зүйн зохицуулалттай харьцуулах.

Судалгааны хамрах хүрээ

3. Энэхүү судалгаанд 2015-2021 оны УДШ-ийн тогтоол, давж заалдах шатны шүүхийн магадлал, түүнчлэн 2019-2021 оны анхан шатны шүүхийн шийдвэрийг түүвэрлэн судалсан боловч эдгээр шийдвэрүүд дунд банк гэмт хэргийн улмаас учирсан хохирол гэж хүү, нэмэгдүүлсэн хүүг олох байсан орлогод тооцон нэхэмжилсэн тохиолдол байгаагүй тул гэм хор, компанийн хувьцаа эзэмшигчийн хариуцлага зэрэг ойлголтыг онолын түвшинд хэрхэн ойлгон хэрэглэдэг хийгээд ИХШХШТХ, Компанийн тухай хууль, ЭХХШТХ зэрэг хуулийн зохицуулалт, гадаад улсуудын туршлагыг үндэслэн судлав.



НЭГ. ГЭМТ ХЭРГИЙН УЛМААС УЧИРСАН ХОХИРЛЫГ ИРГЭНИЙ ЖУРМААР НЭХЭМЖЛЭХ

4. Монгол Улсын хууль зүйн нэвтэрхий толь бичигт *гэмт хэргийн улмаас учирсан хохирол* гэдгийг “эрүүгийн эрх зүйн шинжлэх ухаанд эд хөрөнгийн шинжтэй, мөнгөн дүнгээр илэрхийлж болохуйц гэмт хэргийн хор уршгийн нэгэн төрөл. 2015 оны ЭХ-ийн тодорхойлолтоор бол ЭХ-ийн тусгай ангид заасан гэмт хэргийн улмаас хүний амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгө, бусад эрх, эрх чөлөө, нийтийн болон үндэсний ашиг сонирхол, аюулгүй байдалд шууд учирсан үр дагавар”¹ гэж тодорхойлсон бол, *хохирол* гэдгийг “иргэний эрх зүйд нэг этгээдийн хууль зөрчсөн үйлдлээр нөгөөд учруулсан мөнгөн хэлбэрээр илэрхийлэгдсэн алдагдал, хөнөөл, сүйтгэл. Хохирол нь хэн нэгэн этгээдийн эрх зөрчигдсөнөөс түүнийг сэргээн тогтоолгоход гаргах ёстой зардал, тэрчлэн түүний эд хөрөнгийг алга болгосон ба гэмтээсэн бодит хохирол; хэрэв үүрэг гүйцэтгэгч үүргээ зохих ёсоор биелүүлсэн бол олж авах ёстой байсан орлого, алдсан ашгийг ойлгоно.”² гэж тус тус тодорхойлжээ.
5. ЭХХШТХ-ийн 8.5 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт гэмт хэргийн улмаас учирсан эд хөрөнгийн болон эд хөрөнгийн бус хохирлыг нөхөн төлүүлэх, сэргээлгэхээр шаардлага тавьж байгаа хүн, хуулийн этгээдийг *иргэний нэхэмжлэгч*³ гэж тодорхойлсон. ЭХХШТХ-ийн 8.5 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт зааснаар гэмт хэргийн улмаас эд хөрөнгийн болон эд хөрөнгийн бус хохирол хүлээсэн хүн хуулийн этгээд нь сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч, эсхүл түүний учруулсан эд хөрөнгийн болон эд хөрөнгийн бус хохирлыг хариуцвал зохих этгээдэд холбогдуулан иргэний нэхэмжлэл гаргах эрхтэй бөгөөд тэрхүү нэхэмжлэлийг шүүх уг хэргийн хамт хянан шийдвэрлэнэ.⁴ ЭХХШТХ-ийн 8.5 дугаар зүйлийн 6 дахь хэсэгт гэмт хэргийн улмаас учирсан хохиролтой холбогдолтой нэхэмжлэлийг тухайн эрүүгийн хэрэг шийдвэрлэгдээгүй байхад иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагааны журмаар шийдвэрлэхийг хориглохоор⁵ заасан. Уг хэргийн хамт шийдвэрлэнэ гэдэг нь тухайн эрүүгийн хэрэгтэй хамт шийдвэрлэхийг ойлгож байх бөгөөд эрүүгийн шүүхийн шийдвэрт иргэний нэхэмжлэгч эд хөрөнгийн маргаанаа иргэний журмаар шүүхээр нэхэмжлэх эрхтэйг⁶ дурдаж болдог. Нөгөөтэйгүүр иргэний эрх зүй дэх гэм хор нь зөрчлийн улмаас үүсэх шаардах эрх гэдэг утгаараа янз бүрийн фактаас тухайлбал гэмт хэргийн улмаас, гэрээний үүргээ биелүүлээгүйгээс, захиргааны актаас үүсэх боломжтой.⁷ Эрүүгийн гэмт хэргийн улмаас учирсан хохирлыг иргэний журмаар нэхэмжилж байгаа талаар шүүхийн шийдвэрийн цахим мэдээллийн сангаас үзэхэд ИХ-ийн гэм хорын тохирох зохицуулалтыг хэрэглэн нэхэмжлэл гаргасан байна.
6. Гэм хор учруулснаас үүсэх үүргийн зохицуулалтыг ерөнхий ба тусгай гэсэн хоёр хэсэгт хувааж болно.⁸ Гэм хорын хохирлыг шийдвэрлэхдээ гэм хорын хариуцлага хүлээлгэх эрх зүйн үндсэн хэм хэмжээ болох ИХ-ийн 497.1 дэх хэсгийн зохицуулалтыг эдийн болон эдийн бус гэм хорыг арилгах болон хуулийн бусад тусгайлан заасан зохицуулалтуудтай хамтатган

¹ С.Нарангэрэл, Монгол Улсын хууль зүйн нэвтэрхий толь бичиг, 2021 он, 93 дахь тал.

² Мөн тэнд, 496 дахь тал.

³ ЭХХШТХ, 2002 он. 8.5 дугаар зүйл 1 дэх хэсэг.

⁴ ЭХХШТХ, 2002 он. 8.5 дугаар зүйл 2 дахь хэсэг.

⁵ ЭХХШТХ, 2002 он. 8.5 дугаар зүйл 6 дахь хэсэг.

⁶ НИХДЗШШ-ийн 2020 оны 08 дугаар сарын 21-ний өдрийн 01808 дугаар магадлал.

⁷ М.Ванчигмаа, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаан дахь иргэний нэхэмжлэл, 2019 он, 23 дахь тал.

⁸ Т.Мөнхжаргал, Иргэний эрх зүй үүргийн тусгай төрөл, 1998 он, 145 дахь тал.

хэрэглэнэ. Нийтлэг журмын дагуу ИХ-ийн 497.1, 497.2 дахь заалтаас үзвэл бусдын эрх, амь нас, эрүүл мэнд, нэр төр, алдар хүнд, эд хөрөнгөд хууль бусаар санаатай буюу болгоомжгүй үйлдэл /эс үйлдэхүй/-ээр гэм хор учруулсан этгээд гэм хорыг хариуцан арилгах үүрэгтэй бөгөөд гэм хор учруулсан этгээд тухайн гэм хор учруулахад буруугүй гэдгээ нотолбол хариуцлагаас чөлөөлөгдөнө. Гэм хорын хариуцлага хүлээлгэх үндэслэлийг эрдэмтэд гэм хор учруулагчийн хууль бус үйлдэл, хохирол, үйлдэл ба хохирлын хоорондын шалтгаант холбоо, гэм хор учруулагчийн гэм буруу гэж үздэг байна.⁹ Иймд гэм хорыг арилгах үүрэг нь гэм хор учруулсан этгээдэд үүснэ.

7. Гэм хор учруулсан гэм буруутай этгээд гэм хорыг хариуцан арилгах талаар шүүхийн шийдвэрүүдэд дараах байдлаар дурдсан байна:

Нэхэмжлэгч С, хариуцагч Н. Гэм хорын хохирлын маргаан. Говь-Алтай аймгийн Эрүү, Иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн 2018 оны 06 сарын 21-ний өдрийн 15 дугаар магадлалаас:

“... ИХ-ийн 497 дугаар зүйлийн 497.1-д ...бусдын эрх, амь нас, эрүүл мэнд, нэр төр, алдар хүнд, эд хөрөнгөд хууль бусаар санаатай буюу болгоомжгүй үйлдэл /эс үйлдэхүй/-ээр гэм хор учруулсан этгээд уг гэм хорыг хариуцан арилгах үүрэгтэй... гэж заасан нь тухайн гэм хорын хариуцлагыг гэм хор учруулагчид хүлээлгэхэд түүний санаатай буюу болгоомжгүй үйлдэл, эс үйлдэхүй хуулиар тогтоогдсон байхыг шаардаж байна. ...”¹⁰

Нэхэмжлэгч Ю.Ю, хариуцагч Т.С Гэм хорын хохирлын маргаан. Хан-Уул дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2020 оны 04 дүгээр сарын 30-ны өдрийн 183/ШШ2020/01129 дугаар шийдвэрээс:

“... ИХ-ийн 497 дугаар зүйлийн 497.1-д “бусдын эрүүл мэнд, эд хөрөнгөд хууль бусаар санаатай буюу болгоомжгүй үйлдлээр гэм хор учруулсан этгээд уг гэм хорыг хариуцан арилгах үүрэгтэй” гэжээ. Дээрх хуулийн зохицуулалтаар хариуцагчийн хууль бус үйлдэл байх, гэм буруутай нь эрх бүхий этгээдийн шийдвэрээр нотлогдсон байх, гэм хор учруулсан байх, гэм буруу, хохирол нь хоорондоо шалтгаант холбоотой байх буюу тухайн заалтад тавигдах урьдчилсан нөхцөл бүрдсэн байхыг шаардана. ...”¹¹

Түүнчлэн Нийслэлийн Иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн 2018 оны 03 дугаар сарын 14-ний өдрийн 688 дугаар магадлалын ХЯНАВАЛ хэсэгт Монгол Улсын Үндсэн хуулийн арван зургадгаар зүйлийн 14-т “гэм буруутай нь хуулийн дагуу шүүхээр нотлогдох хүртэл хэнийг ч гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд тооцож үл болно” гэж заасныг үндэслэн хариуцагчийг гэм буруугүйд тооцон хэргийг шийдвэрлэсэн байна.

8. Дээрхээс үзэхэд гэмт хэрэг үйлдсэн гэм буруутай нь шүүхээр тогтоогдсон тохиолдолд гэмт хэргийн улмаас учирсан хохирлыг ИХ-ийн гэм хорын зохицуулалтын дагуу гэм хор учруулагчаас шаардах эрхтэй байхаар ойлгогдож байна.

⁹ Монгол Улсын Иргэний хуулийн тайлбар (Гэрээний бус үүрэг) IV. Уб., 2016 он, 53 дахь тал.

¹⁰ Говь-Алтай аймгийн Эрүү, Иргэний давж заалдах шатны шүүхийн 2018 оны 06 сарын 21-ний өдрийн 15 дугаар магадлал.

¹¹ Хан-Уул дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2020 оны 04 дүгээр сарын 30-ны өдрийн 183/ШШ2020/01129 дугаар шийдвэр.



ХОЁР. БАНКНЫ ХҮҮ, НЭМЭГДҮҮЛСЭН ХҮҮГ ОЛОХ БАЙСАН ОРЛОГОД ТООЦОХ

9. Гэмт хэргийн улмаас учирсан хохирлыг иргэний эрх зүйн гэм хорын журмаар нэхэмжилсэн шүүхийн шийдвэрүүдээс үзэхэд олох байсан орлогыг нэхэмжилсэн нь дийлэнх тохиолдол үйлдвэрлэлийн ослын улмаас эрүүл мэндэд нь хохирол учирч хөдөлмөрийн чадвараа алдсан¹² эсвэл нас барсан¹³, эрүүл мэндэд хохирол учирснаас хохирогч нас барсан тул нөхөн төлбөр гаргуулах¹⁴, цалингийн зөрүүг¹⁵, нэхэмжилсэн байна.
10. Гэм хор нь хохирлоос өргөн ойлголт юм. Гэм хорыг мөнгөөр үнэлж болох хэсгийг буюу эд хөрөнгийн гэм хорыг хохирол гэж тайлбарласан байх бөгөөд хууль зүйн толь бичиг дэх хохирлын тодорхойлолтоос үзвэл хохирол гэдэгт бодит хохирлоос гадна хэрэв үүрэг гүйцэтгэгч үүргээ зохих ёсоор биелүүлсэн бол олж авах ёстой байсан орлого, алдсан ашгийг хамааруулсан байна.
11. Банкны тухай хуулийн 3.1.1-д “банк” гэж хувьцаа эзэмшигчдийн оруулсан мөнгөн хөрөнгөөс бүрдсэн хувь нийлүүлсэн хөрөнгөтэй, хувьцаа эзэмшигч нь эзэмшиж байгаа хувьцааны хэмжээгээр хариуцлага хүлээдэг, бусдын мөнгөн хөрөнгийг хуримтлуулан хадгалж, өөрийн нэрийн өмнөөс зээл олгох, төлбөр тооцоо хийх зэрэг санхүүгийн зуучлалын үйл ажиллагааг Монголбанкны тусгай зөвшөөрөлтэйгөөр эрхэлдэг, ашгийн төлөө хуулийн этгээдийг хэлнэ гэж тодорхойлсон. “**Үндсэн хүү**” гэж зээлийг ашиглавал зохих хугацаагаар зээлдүүлэгчээс тогтоож, зээлдэгч зөвшөөрч гэрээнд заасан хэмжээгээр төлөх хариу төлбөр буюу зээлийн үнийг хэлнэ. Мөн зүйл, заалтын “**нэмэгдүүлсэн хүү**” гэж зээлдэгч авсан зээлээ гэрээнд заасан хугацаандаа буцааж төлөөгүй тохиолдолд зээлдэгчээр үндсэн хүү дээр нэмж төлүүлэхээр тогтоож, гэрээгээр тодорхойлсон хариуцлагын хэлбэрийг хэлнэ.¹⁶ Банк нь ашгийн төлөө байгууллагын хувьд зээлийн гэрээнд заасан түүний олж болох байсан хүү, нэмэгдүүлсэн хүү нь хохиролд хамааруулан ойлгож болохоор байна.
12. Хэдийгээр банк хүү, нэмэгдүүлсэн хүүг олох байсан орлого гэж нэхэмжилсэн тохиолдол гэмт хэргийн улмаас учирсан хохирлыг нэхэмжилсэн шүүхийн шийдвэрүүд дунд байхгүй ч дээрх тодорхойлолтуудаас авч үзвэл банкны зээлийн гэрээнд заасан хүү, нэмэгдүүлсэн хүүг олох байсан орлого гэж үзэн гэм хорын журмаар нэхэмжлэх боломжтой байж болох юм.

ГУРАВ. КОМПАНИЙН ХАРИУЦЛАГЫН ОНОЛЫН ОЙЛГОЛТ, ГАДААД УЛСЫН ТУРШЛАГА

13. Монгол Улсын эрх зүйн холбогдох зохицуулалтын хувьд Компанийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.3 дахь хэсэгт “Хувьцаа эзэмшигч нь компанийн хүлээх үүргийг хариуцахгүй бөгөөд гагцхүү өөрийн эзэмшлийн хувьцааныхаа хэмжээгээр хариуцлага хүлээнэ”, 9 дүгээр зүйлийн 9.5 дахь хэсэгт “Хувьцаа эзэмшигчийн компанид оруулсан эд хөрөнгө, эд хөрөнгийн

¹² Дорнод Аймгийн Эрүү, Иргэний давж заалдах шатны шүүхийн 2020 оны 09 дүгээр сарын 21-ний өдрийн 201/МА2020/0025 дугаар магадлал.

¹³ УДШ-ийн 2018 оны 12 сарын 07-ны өдрийн 001/ХТ2018/01805 дугаар тогтоол.

¹⁴ УДШ-ийн 2018 оны 02 сарын 08-ны өдрийн 001/ХТ2018/00239 дугаартай тогтоол.

¹⁵ Орхон аймгийн Иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн 2019 оны 05 дугаар сарын 21-ний өдрийн 71 дугаар магадлал.

¹⁶ Иргэний хуулийн 44, 45, 46 дугаар бүлэг, банк, эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, төлбөр тооцоо, зээлийн үйл ажиллагааны тухай хуулийн зарим зүйл, заалтыг тайлбарлах тухай, УДШ-ийн 53 дугаар тогтоол.



эрх нь хувийн эд хөрөнгө, эд хөрөнгийн эрхээс тодорхой зааглагдаагүй бол уг хувьцаа эзэмшигч өөрийн бүх эд хөрөнгө, эд хөрөнгийн эрхээр компанийн өр төлбөрийг давхар хариуцна” хэмээн компанийн хувьцаа эзэмшигчийн хүлээх хариуцлагыг хуульчлан тодорхойлсон байдаг.

Хувьцаа эзэмшигчийн хариуцлага, түүний хэлбэр

14. Хувьцаа эзэмшигчийн хариуцлага гэж компанийн өр төлбөрийг хувьцаа эзэмшигч хүлээх эсэхэд хамаарах хариуцлагын хэлбэрийг хэлэх¹⁷ ба онолын хувьд дэлхий нийтэд түгээмэл байдлаар компанийн өр төлбөрийг хувьцаа эзэмшигчийн хөрөнгөөр нөхөн хангах эсэхийг шалгуур болгон дараах ангилалд хуваадаг. Үүнд:
- Хувьцаа эзэмшигчийн бүрэн хариуцлага;
 - Хувьцаа эзэмшигчийн хувь тэнцүүлсэн хариуцлага;
 - Хувьцаа эзэмшигчийн хязгаарлагдмал хариуцлага.¹⁸
15. **Хувьцаа эзэмшигчийн бүрэн хариуцлага** нь хувьцаат компанийн эрх зүйн зохицуулалтын эхэн үед хэрэгжиж байсан хариуцлагын хэлбэр бөгөөд компанийн өр төлбөрт хувьцаа эзэмшигч хувийн хөрөнгөөр *бүрэн хариуцлага* хүлээх агуулгыг илэрхийлдэг боловч эдийн засгийн үр ашиг нь *хязгаарлагдмал хариуцлагын* үр ашигтай харьцуулахад харьцангуй бага байдаг¹⁹ гэж үздэг.
16. Сүүлийн үед *морал хазардын*²⁰ асуудлын хүрээнд компанийн хяналтын хувьцаа эзэмшигчид бүрэн хариуцлага хүлээлгэх үзэл санаа хүчтэй яригдаж байна. Энэхүү үзэл санааны төлөөлөгч нь Мэндэлсон²¹ юм. Түүний дэвшүүлсэн хяналтын буюу ноёлогч хувьцаа эзэмшигчийн бүрэн хариуцлага нь онолын хувьд өндөр ач холбогдолтой боловч, бүрэн хариуцлагыг дэвшүүлсэн тул хүлээн зөвшөөрөх боломжгүй гэх судлаачид олонхыг эзэлдэг.²² Ийнхүү бүрэн хариуцлага нь хувьцаа эзэмшигчийн хариуцлагын хэлбэрийн хүрээнд төдийлөн түгээмэл бус байх бөгөөд онолын хувьд ч нийтлэг байдлаар зөвшөөрөгдөөгүй байна.
17. **Хувьцаа эзэмшигчийн хувь тэнцүүлсэн хариуцлага** нь компанийн эрх зүйн зохицуулалтын хөгжлийн явцад тодорхой хүрээнд хэрэгжиж байсан хариуцлагын хэлбэр²³ ба энэ нь компанийн өр төлбөрт хувьцаа эзэмшигчид өөрийн эзэмшлийн хувьцааны тоонд хувь тэнцүүлэн хариуцлага хүлээх агуулгыг илэрхийлдэг.²⁴ Компани нь үйл ажиллагаа явуулахын тулд гэрээний эрх зүйн харилцаанд оролцох төдийгүй, шүүхэд хариуцагчаар орж өр төлбөрийн асуудалд орж болдог.²⁵ Зарим тохиолдолд нэхэмжлэгч буюу хохирогч этгээд нөхөн төлбөрийг хангалттай хэмжээнд гаргуулахын тулд компаниас гадна хувьцаа

¹⁷ <https://www.companydebt.com/shareholders-liable-company-debts/>. (Сүүлд үзсэн: 2021.10.19).

¹⁸ Г.Давааням, Компани, арилжааны эрх зүйн тулгамдсан асуудлууд, УБ., 2020 он, 1 дэх тал.

¹⁹ Г.Давааням, Морал хазардын асуудлаас үүдэх толгой компанийн хариуцлага, Хязгаарлагдмал хариуцлагын үр ашгийн талаар, УБ., 2020 он, 18-19 дэх тал.

²⁰ Энэ нь талууд гэрээ хийхдээ өмч хөрөнгө, өр төлбөр, хүлээх хариуцлага, зээлийн болон өрийн мэдээллийн талаар төөрөгдүүлсэн мэдээлэл өгснөөс үүдэх эрсдэл юм.

<https://www.investopedia.com/terms/m/moralhazard.asp>. (Сүүлд үзсэн: 2021.10.17).

²¹ Г.Давааням, Компани, арилжааны эрх зүйн тулгамдсан асуудлууд, 2020 он, 2 дахь тал.

²² Мөн тэнд.

²³ Мөн тэнд.

²⁴ Gordon G. Sollars, An Appraisal of Shareholder Proportional Liability, 32, 329–345 (2001).

<https://link.springer.com/article/10.1023/A:1010768824610>. (Сүүлд үзсэн: 2021.10.19).

²⁵ Shareholder Liability: Piercing the Corporate Veil <https://www.svlaw.ca/blog/details/item/shareholder-liability-piercing-the-corporate-veil>. (Сүүлд үзсэн: 2021.10.21).

эзэмшигчтэй холбогдуулан нэхэмжлэлийн шаардлага гаргах тохиолдол байдаг тул гадаад улсуудаас Канад улсын шүүхийн байгууллага хувь тэнцүүлсэн хариуцлагын хэлбэрийг ховор тохиолдолд хэрэглэдэг байна.²⁶

18. Дэлхийн улс орнуудад буюу компанийн эрх зүйд “компанийн хөшгийг цоолох” буюу “piercing the corporate veil”, “lifting the veil”²⁷, “separate legal personality”²⁸ гэх ойлголт байх ба энэ нь онцгой тохиолдолд компанийн хувьцаа эзэмшигч нь компанийн өр төлбөрийг өөрийн эзэмшлийн хувьцаанд хувь тэнцүүлэх байдлаар хариуцан үүрэг хүлээхийг хэлнэ.²⁹ Энэхүү онцгой тохиолдол нь ихэвчлэн хаалттай компанийн хувьд яригддаг байна.³⁰
19. Хувьцаа эзэмшигч болон гүйцэтгэх удирдлага давхар хариуцлага хүлээх асуудал нь маргааны тохиолдол бүрээсээ шалтгаалан өөр өөр байх ба шүүхээс тухайн компанийг хувьцаа эзэмшигч нь өөрийн хариуцлагыг хязгаарлах, багасгах зорилгоор залилах сэдэлтэй байгуулсан эсэх, тийнхүү үнэнч бус хандан компанийг үүсгэн байгуулсан эсэх зэргийг тодруулбал зохино гэж үздэг³¹ төдийгүй маргааны тохиолдол бүрээс шалтгаалан “компанийн хөшгийг цоолон” хувьцаа эзэмшигчид хариуцлага хүлээлгэх эсэхийг шүүх шийдвэрлэнэ.³²
20. Энэхүү онолын үзэл баримтлалын дагуу нэхэмжлэгч талаас хариуцагч хуулийн этгээдийн зорилго нь тусдаа аж ахуйн нэгж хэлбэрээр үйл ажиллагаа явуулах биш гэдгийг нотлох ёстой ба хуулийн этгээд бол зүгээр л халхавч бөгөөд түүнийг хувьцаа эзэмшигчидтэй адилхан авч үзэх ёстой гэж үздэг байна.³³ Компанийн эрх зүйн ерөнхий зарчмаас хазайж “компанийн хөшгийг цоолох” тохиолдлыг ашиглан шийдвэр гаргахад зайлшгүй шалгах шаардлагатай хэд хэдэн шалгуур үзүүлэлт бий. Тэдгээр нь:
1. Бизнесийн албан ёсны байдал - Байгууллага нь улсын бүртгэлд бүртгүүлсэн эсэх, дүрмээ баталсан эсэх, хурал болоход тэмдэглэл хөтөлдөг байсан эсэх;
 2. Бизнесийн хөрөнгө - Бизнес эрхлэгчид хувийн болон бизнесийн хөрөнгө эсвэл бусад хөрөнгөө зааглан ялгасан эсэх буюу компанийн хөрөнгөөс хувьцаа эзэмшигчийн хувийн хөрөнгийг ялган зааглагдсан эсэх;
 3. Бизнесийн ашиг орлого олдог байдал - Бизнес нь зохих хэмжээний ашиг олдог уу эсвэл хариуцлагын зохих хамгаалалттай эсэх;
 4. Хувьцаа эзэмшигчдийн чиг үүрэг - Бизнес хөрөнгө оруулсан гишүүд үүрэг, хариуцлагаа дагаж мөрддөг эсэх эсвэл түүнийгээ гажуудуулдаг эсэх. Дээрх 4 шалгуурын нэг нь сул эсхүл доголдолтой тохиолдолд хязгаарлагдмал хариуцлага эвдэгдэх нөхцөл болдог байна.³⁴
21. Түүхийн хувьд *хувь тэнцүүлсэн хариуцлага* нь 1849-1931 оны хооронд АНУ-ын Калифорния мужид үйл ажиллагаа явуулж байсан компанийн хувьцаа эзэмшигчид хувь тэнцүүлсэн

²⁶ Мөн тэнд.

²⁷ Andrew Hicks & S.H. Goo, Company law (6th edition), 102-104 (2008).

²⁸ <https://www.lawteacher.net/cases/salomon-v-salomon.php> (Сүүлд үзсэн: 2021.10.23).

²⁹ Piercing the Corporate Veil, https://www.law.cornell.edu/wex/piercing_the_corporate_veil, (Сүүлд үзсэн: 2021.10.20).

³⁰ Мөн тэнд.

³¹ Мөн тэнд.

³² Are shareholders of the corporation personally liable for obligations of the corporation? https://thebusinessprofessor.com/en_US/business-governance/shareholder-personal-liability-for-corporate-obligations, (Сүүлд үзсэн: 2021.10.21).

³³ Мөн тэнд.

³⁴ Мөн тэнд.

хариуцлага хүлээж байснаас эхтэй.³⁵ Сүүлийн үед АНУ-ын зарим судлаачид *морал хазардын* асуудлаас үүдсэн хувьцаа эзэмшигчийн хариуцлагыг тодруулах хүрээнд хувь тэнцүүлсэн хариуцлагыг дэвшүүлсэн байна. Энэ үзэл санааны төлөөлөгч болох Хансман болон Краакман (1991) нар нь бусдад гэм хор учруулсан компанийн хувьцаа эзэмшигчид түүний хувьцааны тоонд хувь тэнцүүлэн төлбөрийг хүлээлгэх нь зүйтэй хэмээн үзсэн.³⁶

22. Гэвч Хансман болон Краакман нарын дэвшүүлсэн хувьцаа эзэмшигчийн хувь тэнцүүлсэн хариуцлага нь 1/хэрэгжих боломжгүй ба хэрэгжсэн ч шүүхийн зардал, төлбөрийг гаргуулахад ихээхэн хүндрэл үүсэх, 2/Хансман болон Краакман нарын төсөөлж байгаа шиг “компанийн хөшгийг цоолж” шийдвэрлэснээр хязгаарлагдмал хариуцлагын дутагдлыг нөхөх эсэх нь эргэлзээтэй, 3/компанийн үйл ажиллагаанд идэвхгүй оролцоотой жижиг хувьцаа эзэмшигчид хувь тэнцүүлсэн хариуцлага ногдуулах нь тохиромжтой бус гэх шүүмжүүдийг дагуулдаг. Ийнхүү хувь тэнцүүлсэн хариуцлага нь хувьцаа эзэмшигчийн хариуцлагын хүрээнд ач холбогдол бага бөгөөд түүний хэрэгжих боломж хомс³⁷ хэмээн үзэж болохоор байна.
23. **Хувьцаа эзэмшигчийн хязгаарлагдмал хариуцлага** нь компанийн ямар нэг өр төлбөрт хувьцаа эзэмшигчийн хөрөнгөөр үүрэг хүлээхгүй байхыг хэлнэ.³⁸ Энэ нь компанийг байгуулахын нэг давуу талд тооцогддог.³⁹ Хязгаарлагдмал хариуцлагын үүсэл нь 12 дугаар зууны Итали Улсад худалдааны эрсдэлийг хязгаарлах аж ахуй нэгжийн хүрээнд комменда (commenda)-ын хэлбэр хөгжиж эхэлснээс үүсэлтэй.⁴⁰
24. 1408 оны Флоренц хотод аж ахуйн үйл ажиллагаанд хөрөнгө оруулсан гишүүн “коммендатор”-ийн хариуцлагыг түүний коммендад оруулсан хөрөнгийн хэмжээгээр хязгаарлаж байсан.⁴¹ Мөн Комменда нь дундад зууны Англи, Герман, Скандинавын орнуудад ч түгээмэл оршиж байжээ.⁴² 1600 оны дунд үеэс Англи улсад хязгаарлагдмал хариуцлага бүхий компанийн хэлбэр үзэгдэх болсон ч эзэн хааны тусгай зөвшөөрөл буюу (royal charter)-гүйгээр хувьцаат компани байгуулахыг хориглосон 1720 оны хууль ‘Bubble act’ гарснаар хувьцаат компанийн хөгжил тасалдсан. Улмаар хязгаарлагдмал хариуцлага нь анх удаа 1855 оны “Limited liability act”-ын хүрээнд хуульчлагдсан байдаг. Харин АНУ-д хувьцаат компанийн хэлбэр хүчтэй хөгжиж 1830 он гэхэд хувьцаа эзэмшигчийн хязгаарлагдмал хариуцлага түгээмэл байдлаар хэрэглэгдэх болсон.
25. Өнөө үед АНУ-ын Загвар Компанийн хуульд хувьцаа эзэмшигч нь “өөрийн үйл ажиллагааны үр дүнд бий болсон хувийн хариуцлагаас өөр компанийн үйл ажиллагаа, өр төлбөрт хувийн хариуцлага хүлээхгүй” хэмээн тусгагдан баталгаажсан.⁴³ Өөрөөр хэлбэл, хувьцаа эзэмшигч

³⁵ Г.Давааням, Компани, арилжааны эрх зүйн тулгамдсан асуудлууд, 2020 он, 2 дахь тал.

³⁶ Мөн тэнд.

³⁷ Мөн тэнд.

³⁸ <https://www.investopedia.com/terms/l/limitedliability.asp>, (Сүүлд үзсэн: 2021.10.19).

³⁹ Shareholder Liability: Piercing the Corporate Veil <https://www.svlaw.ca/blog/details/item/shareholder-liability-piercing-the-corporate-veil>, (Сүүлд үзсэн: 2021.10.21).

⁴⁰ Комменда нь хөрөнгө оруулагч гишүүн болох “коммендеторт” нь аж ахуйн үйл ажиллагаа эрхлэгч гишүүн болох “тректатор”-т хөрөнгөө оруулах замаар үйл ажиллагаа явуулах нөхөрлөлийн уламжлалт хэлбэр юм. Gordon G. Sollars, An Appraisal of Shareholder Propotional Liability, Journal of Business Ethics 32, 329, 330 (2001), Г.Давааням, Компани, арилжааны эрх зүйн тулгамдсан асуудлууд, 2020 он, 4 дэх тал.

⁴¹ Mitchell, W, Early Forms of Partnership, 186 (1907), Г.Давааням, Компани, арилжааны эрх зүйн тулгамдсан асуудлууд, 2020 он, 4 дэх тал.

⁴² Мөн тэнд.

⁴³ Model Business Corporation Act, 6.22. (2016 version).

компанийн өр төлбөрт компанид оруулсан хөрөнгийн хэмжээнээс илүү хариуцлага хүлээхгүй байх нь компанийн эрх зүйн үндсэн зарчим болон хэвшин тогтсон гэж үзэж болохоор байна.

Монгол Улсын эрх зүйн зохицуулалт

26. Монгол Улсад компанийн эрх зүйн харилцааг 2011 оны шинэчлэн найруулсан Компанийн тухай хуулиар зохицуулдаг. Уг хууль нь хувьцаа эзэмшигчийн хязгаарлагдмал хариуцлагыг хуульчлан тогтоосон. Компанийн тухай хуулийн 9.3 дахь хэсэгт “Хувьцаа эзэмшигч нь компанийн хүлээх үүргийг хариуцахгүй бөгөөд гагцхүү *өөрийн эзэмшлийн хувьцааныхаа* хэмжээгээр хариуцлага хүлээнэ” хэмээн зохицуулсан. Энэ заалт нь 1999 оны Компанийн тухай хуулиас эхтэй. 1999 оны хуулийн 9.3 дахь хэсэгт “Хувьцаа эзэмшигч нь компанийн хүлээх үүргийг хариуцахгүй бөгөөд гагцхүү *эзэмшиж байгаа хувьцааны* хэмжээгээр хариуцлага хүлээнэ” хэмээн зааж байжээ. 1999 болон 2011 оны Компанийн тухай хуулийн дээрх зохицуулалт нь нэр томьёоны хувьд тодорхой ялгаатай боловч агуулгын хувьд адил байна.⁴⁴
27. Харин энэхүү хязгаарлагдмал хариуцлагын зарчмаас хазайх тохиолдол нь 1999 оны Компанийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 5 дахь хэсэг⁴⁵, 2011 оны Компанийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.5 дахь⁴⁶ хэсгүүдэд заасан тохиолдол болно.
28. Гэвч шүүхийн практикт Компанийн тухай хуулийн 9.3 дахь хэсэгт заасан “хувьцаа эзэмшигч нь ... гагцхүү өөрийн эзэмшлийн хувьцааныхаа хэмжээгээр хариуцлага хүлээнэ.” гэснийг хоёр өөр агуулгаар тайлбарлан хэрэглэж байна. Үүнд:
1. Шүүхээс хувьцаа эзэмшигчийн *хязгаарлагдмал хариуцлагын* мөн чанарын дагуу “хувьцаа эзэмшигч компанийн хувьцааг эзэмшсэний оронд хөрөнгө оруулахаас бусад компанийн үүрэг хариуцлага хүлээхгүй” хэмээн ойлгож, компанийн өр төлбөрийн өмнө хүлээх хувьцаа эзэмшигчийн хариуцлагыг бүрэн үгүйсгэж байна.
 2. Шүүхээс хувьцаа эзэмшигчийн *хувь тэнцүүлсэн хариуцлагын* үүднээс “хувьцаа эзэмшигч компанид эзэмшиж байгаа хувьцааны хэмжээгээр өр төлбөрийг хувь тэнцүүлэн хариуцна” хэмээн ойлгож, компанийн өр төлбөрийн өмнө хүлээх хувьцаа эзэмшигчийн хувь тэнцүүлсэн хариуцлагыг хүлээн зөвшөөрч байна.⁴⁷
29. Ерөнхий хандлагын хувьд Компанийн тухай хуулийн 9.3 дахь хэсгийг хэрэглэхдээ хувьцаа эзэмшигчийн хязгаарлагдмал хариуцлагын зарчимд үндэслэн тайлбарлаж байх ба шүүхээс хувьцаа эзэмшигчид *бүрэн хариуцлага* хүлээлгэхийн тулд Компанийн тухай хуулийн 9.3 дахь хэсгийн зохицуулалтыг бус 9.5 дахь хэсэг болон 6.6 дахь хэсгийн хувьцаа эзэмшигчийн компанид оруулсан хөрөнгө, эд хөрөнгийн эрх нь түүний хувийн эд хөрөнгө, эд хөрөнгийн эрхээс тодорхой зааглагдаагүй бол компанийн өр төлбөрийг хувийн хөрөнгөөр бүрэн хариуцаж болох тухай зохицуулалтыг үндэслэх нь зүйтэй гэж судлаач Г.Давааням бүтээлдээ дурджээ.⁴⁸

⁴⁴ Г.Давааням, Компани, арилжааны эрх зүйн тулгамдсан асуудлууд, 2020 он, 5 дахь тал.

⁴⁵ Хувь нийлүүлэгчийн компанид оруулсан эд хөрөнгө, эд хөрөнгийн эрх нь хувийн эд хөрөнгө, эд хөрөнгийн эрхээс тодорхой зааглагдаагүй бол уг хувь нийлүүлэгч өөрийн бүх эд хөрөнгө, эд хөрөнгийн эрхээр компанийн өр төлбөрийг давхар хариуцна.

⁴⁶ Хувьцаа эзэмшигчийн компанид оруулсан эд хөрөнгө, эд хөрөнгийн эрх нь хувийн эд хөрөнгө, эд хөрөнгийн эрхээс тодорхой зааглагдаагүй бол уг хувьцаа эзэмшигч өөрийн бүх эд хөрөнгө, эд хөрөнгийн эрхээр компанийн өр төлбөрийг давхар хариуцна.

⁴⁷ Мөн тэнд.

⁴⁸ Г.Давааням, Компани, арилжааны эрх зүйн тулгамдсан асуудлууд, 2020 он, 13 дахь тал.

30. Компанийн хариуцлагын төрлийн хувьд зарим тохиолдолд хязгаарлагдмал хариуцлага хүлээлгэнэ гэж шийдвэрлэж байгаа тохиолдол байхад⁴⁹ хувь тэнцүүлсэн хариуцлага хүлээлгэнэ гэж ялгаатай шийдвэрлэж байгаа шийдвэрүүд⁵⁰ мөн байна.
31. Иймд хувьцаа эзэмшигчийн хувь тэнцүүлсэн хариуцлагын хүрээнд компанийн өр төлбөрийг хувьцаа эзэмшигч хариуцах тохиолдол байж болох ба энэхүү хариуцлагын үндсэнд гэм хорын хариуцлага хүлээх боломжтой.

Компанийн хувьцаа эзэмшигчийн гэм хорын хариуцлагын талаар

32. Бусдад гэм хор учруулсан этгээдээр хохирлыг нөхөн төлүүлэхийн тулд уг этгээдийн гэм буруу, учирсан хохирлын хооронд шалтгаант холбоотой байх тухай зарчим дэлхийн улс орнуудад нийтлэг хэрэгжиж байна.⁵¹ Гэм буруугүй бол хариуцлага хүлээхгүй байх энэхүү ерөнхий зарчим нь либерал-индивидуализмын үзэл санаатай нягт холбоотойгоос гадна, үйлдвэржсэн улс орнуудад дэлгэрсэн нийгмийн дарвинизмын “хөндлөнгөөс оролцох онцгой шалтгаан байхгүй бол алдагдал хаана үүснэ тэнд нь орхих нь зөв бодлого” гэсэн үзэл хүчтэй байсантай холбоотой.⁵²
33. Гадаад улсуудын хувьд компанийн эрх зүйд хэрэглэгддэг үндсэн зарчим болох хязгаарлагдмал хариуцлагын зарчмаас хазайж “компанийн хөшиг цоолох” тохиолдлыг тайлбарлан шийдвэрлэсэн⁵³ цөөн тооны маргаан байх ба үүнд жишээлбэл: Англи улсад шийдвэрлэгдсэн *Salomon v Salomon*⁵⁴, *DHN Food Distributors Ltd v Tower Hamlets London Borough Council*⁵⁵, *Woolfson v Strathclyde Regional Council*⁵⁶, АНУ-д шийдвэрлэгдсэн *Walkovsky v. Carlton*⁵⁷, *In re JNS Aviation, LLC*⁵⁸ гэх маргаануудыг дурдаж болохоор байна.

⁴⁹ Шийдвэр гүйцэтгэлийн үйл ажиллагааны явцад компанийн төлөх төлбөрт хувьцаа эзэмшигч хуулийн этгээдийн өмчлөлийн хөрөнгийг хураасан нь хууль зөрчсөн байна, хувьцаа эзэмшигч нь компанийн үүргийг хариуцахгүй-Г.Давааням, Компани, арилжааны эрх зүйн тулгамдсан асуудлууд, 2020 он, 7 дахь тал, УДШ-ийн 2016 оны 12 сарын 9-ний өдрийн 001/ХТ2016/011373 дугаар тогтоол; Компанийн хувьцаа эзэмшигчийн хөрөнгийг компанийн өр төлбөрт битүүмжлэн хураасан тогтоолуудыг хүчингүй болгуулахыг хүссэн нэхэмжлэлийн шаардлагыг хангаж шийдвэрлэх үндэслэлтэй байна-Г.Давааням, Компани, арилжааны эрх зүйн тулгамдсан асуудлууд, 2020 он, 9 дэх тал, Баянзүрх, Сүхбаатар, Чингэлтэй дүүргийн анхан шатны шүүхийн 2015 оны 10 сарын 6-ны өдрийн 6929 дугаар шийдвэр.

⁵⁰ Хувьцаа эзэмшигч 4 гишүүнтэй хуулийн этгээдийн хариуцлагад 2 хувьцаа эзэмшигчийн төлбөр төлөгч хэмээн тодорхойлж хувьцаа эзэмшигчээс ... төгрөг гаргуулах нь Компанийн тухай хуулийн 9.3 дахь хэсгийн зөрчсөн гэж үзэхгүй, тус 2 хувьцаа эзэмшигчийн эзэмшлийн хувьцааны хэмжээгээр хувь тэнцүүлэн өр төлбөрийг гаргуулахаар шийдвэрлэсэн, Сүхбаатар дүүргийн шүүхийн 2013 оны 2 сарын 27-ны 513 дугаар шийдвэр, Г.Давааням, Компани, арилжааны эрх зүйн тулгамдсан асуудлууд, 2020 он, 10 дахь тал; Б ХХК-ийн 49 хувийн хувьцааг В ХХК эзэмшиж байгаа тул В ХХК-д хувь тэнцүүлсэн хариуцлага оногдуулж шийдвэрлэсэн-Чингэлтэй дүүргийн шүүхийн 2019 оны 9 сарын 17-ны өдрийн 6228 дугаар шийдвэр, Г.Давааням, Компани, арилжааны эрх зүйн тулгамдсан асуудлууд, 2020 он, 11 дэх тал.

⁵¹ Ж.Оюунтунгалаг, Харьцуулсан иргэний эрх зүй, 2013 он, 96 дахь тал.

⁵² Ж.Оюунтунгалаг, Гэм хор учруулснаас үүсэх үүргийн тусгай төрөл: Төрийн албан хаагчийн учруулсан гэм хорыг төр хариуцан арилгах асуудал, Хууль дээдлэх ёс сэтгүүл, цуврал 57, дугаар 2, 2016 он, 45 дахь тал.

⁵³ Andrew Hicks & S.H. Goo, *Company law* (6th edition), 102 (2008).

⁵⁴ <https://www.lawteacher.net/cases/salomon-v-salomon.php>, (Сүүлд үзсэн: 2021.10.22).

⁵⁵ <https://www.lawteacher.net/cases/dhn-v-tower-hamlets.php>, (Сүүлд үзсэн: 2021.10.22).

⁵⁶ <https://www.lawteacher.net/free-law-essays/company-law/lifting-the-veil-separation-of-the-personality-company-law-essay.php> (Сүүлд үзсэн: 2021.10.22).

⁵⁷ <https://www.lexisnexis.com/community/casebrief/p/casebrief-walkovszky-v-carlton>, (Сүүлд үзсэн: 2021.10.22).

⁵⁸ <https://casetext.com/case/in-re-jns-aviation> 4? cf chl jschl tk =pmd JH02ywlyl ecEUtrnpsmQ9I57YVv33nNwb4jfhT Id4-1634904791-0-gqNtZGzNAmWjcnBsZQnl (Сүүлд үзсэн: 2021.10.22).

34. Дурдсан маргаануудын агуулгыг товчилбол:

Маргаан	Агуулга	Шүүхийн шийдвэр
Salomon v Salomon	Salomon гэх этгээд нь хувиараа гутал хийж зардаг байжээ. Тэрээр өөрийн хүүхдүүд, дотын хүмүүстэйгээ нийлэн компани байгуулахаар шийдсэн ба ихэнх хувьцааг өөрөө эзэмшиж байжээ. Тэрээр компанийн нэрээр зээл авсан ба бизнес нь амжилтгүй болж эхэлснээс үүдэн зээлээ төлөх боломжгүй болжээ. Иймд зээлдэгч нь Salomon-оос нөхөн төлбөр гаргуулахыг шаардан нэхэмжлэл гаргасан байна.	Хязгаарлагдмал хариуцлагатай компанийг хуульд зааснаар байгуулахад тавигдах шаардлагыг тодорхойлсон. Давж заалдах шатны шүүхээс Salomon-ыг компанийг төлөөлж хувиараа үйл ажиллагаа явуулсан тул хувиараа хариуцлага хүлээх үндэслэлтэй гэсэн бол дээд шатны шүүх нь энэхүү шийдвэрийг хүчингүй болгож “тус компани нь хуулийн дагуу байгуулагдсан ба компанийн хөрөнгө нь хувьцаа эзэмшигч нарын хөрөнгөөс зааглагдсан ⁵⁹ , өөрийн гэсэн тамга тэмдэг эрхлэх үйл ажиллагаа бүхий байна. Иймд хувьцаа эзэмшигчийн хариуцлагын хязгаар, компанийн хязгаарын асуудлыг тодруулах шаардлагатай төдийгүй дээрх хоёрыг бие даасан бүрэн эрх бүхий этгээдүүд гэж үзэх нь зохилтой байна. Компанийг сурталчлах, таниулахад оролцсон этгээдүүд нь компанийн эрх, үүрэг хариуцлагыг тодорхойлоход хамааралгүй” гэжээ. Энэхүү маргаанаас дамжуулан “компанийн хөшиг цоолох” ойлголт түгээмэл хэрэглэгдэж эхэлжээ.
DHN Food Distributors Ltd v Tower Hamlets London Borough Council	DHN буюу толгой компани нь хоёр охин компанийн нийлэн босгосон холдинг компани байсан. DHN-ийн 100 хувийн хувьцааг эзэмшдэг хоёр охин компани байсан ба нэг охин компани нь DHN-ийн эзэмшдэг газрыг өмчилсөн, нөгөө нь DHN ашигладаг тээврийн хэрэгслийг өмчилдөг байжээ. Газрыг албадан худалдах шаардлага тулгарсан ба DHN компанийн зүгээс бизнест нь саад учруулсны төлөө нөхөн төлбөр авахыг хүссэн байна. Нэг охин компанид нь газрын нөхөн төлбөр гэж өгсөн.	Компаниудын группийн хувьд “компанийн хөшгийг цоолох” тохиолдлыг шийдвэрлэх нь Шүүхээс групп болсон компаниуд нь хамтран ажилласан буюу түншүүд байсан гэж үзвэл “компанийн хөшгийг цоолон” шийдвэрлэх боломжтой. Давж заалдах шатны шүүхээс “охин компаниуд нь толгой компаниаар нягт уялдаатай ажиллах ёстой. Энэ гурван компаниас харахад тэднийг нөхөрлөл буюу түншүүд гэж үзэж болохоор байна. Иймд хариуцлагын асуудалд тэднийг ялгаж үзэх буюу зааглан үзэх боломжгүй, ялгамжтай хандаж болохгүй гэж үзэж байна. Энэ шийдвэрийг зөвхөн охин компаниуд нь 100 хувь эзэмшиж, толгой компанийн хөрөнгийг эзэмшихээс өөр зорилгогүй тохиолдолд л хэрэглэж болох юм. Харин нэг компани нөгөө компанийнхаа өрийг хариуцах эсэх

⁵⁹ https://www.youtube.com/watch?v=z9R_1XCOPCw (Сүүлд үзсэн: 2021.10.24).

		маргааныг шийдвэрлэхэд энэ шийдвэрийг хэрэглэхгүй.
Woolfson v Strathclyde Regional Council	‘A’ хязгаарлагдмал компани таван байрнаас бүрдсэн дэлгүүрт жижиглэн худалдааны бизнес эрхэлдэг байжээ. Эдгээр байруудын гурав нь Вулфсоны, нөгөө хоёр нь өөр нэг хязгаарлагдмал компани "B"-ийн эзэмшилд байсан. Вулфсон нь "A" компанийн цорын ганц захирал байсан бөгөөд "A" компанийн гаргасан 1000 ширхэг хувьцааны 999 ширхгийг эзэмшдэг байсан ба үлдсэн хувийг эхнэр нь эзэмшдэг байв. Вулфсон мөн "B" компанийн гаргасан 30 хувьцааны 20-ийг эзэмшиж, үлдсэн 10 хувьцааг нь түүний эхнэр эзэмшиж байжээ.	Шүүхээс “Орон нутгийн засаг захиргаа байрыг албадан хураах үед Вулфсон болон 'B' компани хоёулаа Газрын шүүхээс нөхөн төлбөр авахыг хүссэн бөгөөд тэд ийм нөхөн төлбөр авах эрхгүй” гэж үзсэн. Бизнес эрхэлж буй компани нь газрын эздэд ямар ч хяналт тавьдаггүй байсан тул тэдгээрийг эдийн засгийн хувьд нэгдмэл нэгж гэж үзэх боломжгүй байсан тул Соломоны дүрэм үйлчилнэ гэж шийдсэн байдаг. Шүүхийн шийдвэрээр дараах хоёр нөхцөлийг хангасан тохиолдолд компанийн хөшгийг цоолж шийдвэрлэнэ гэж үзсэн. Үүнд: • Хязгаарлагдмал хариуцлагыг урвуулан ашиглах зорилгоор залилан мэхэлсэн эсвэл хууль бус үйлдэл хийх зорилго агуулсан байх; • Тэдгээр нөхцөл байдлыг үүсгэсэн компанийн гишүүдэд л хамаарна.
Walkovsky v. Carlton	АНУ-ын иргэн Валковскийг зам хөндлөн гарч байхад нь СК корпорацийн тээврийн хэрэгслийн /такси/ жолооч гэмтээж түүний эрүүл мэндэд гэм хор учруулжээ. Ингээд тэрээр Карлтон буюу хариуцагч тал, түүнчлэн хариуцагчийн компанийн эсрэг нэхэмжлэл гаргажээ. Учир нь хариуцагч нь тухайн улсад үйл ажиллагаа явуулдаг таксины үйлчилгээний компаниудын 10 ширхэг таксиг өөрийн нэр дээр бүртгүүлсэн ба хуулиар тогтоосон зохих хамгийн бага хэмжээний даатгалыг төлдөг байсан байна. Нэхэмжлэгч нь нэхэмжлэлийн шаардлагын үндэслэлдээ эдгээр таксины үйлчилгээний компаниудыг нэг компани гэж үзэх ёстой. Учир нь Карлтон тэдний хувьцааг эзэмшиж байна. Карлтоныг мөн тээврийн хэрэгслээс үүдэн эрүүл мэндэд нь гэм хор учруулж болохуйц нөхцөл байдалд байдаг олон нийтийг залилан мэхэлсэн /компанийн бүтэц нь залилан хийх шинжтэй/ гэсэн үндэслэл дэвшүүлсэн.	Шүүхээс энэхүү маргааныг шийдвэрлэхдээ хэрэв Карлтон нь тухайн өөрийн гэсэн компаниа бүрэн удирдаж байсан бол “respondeat superior” буюу ажилтны буруутай үйл ажиллагаанаас үүдэн учирсан хохирлыг удирдлага нь нөхөн төлөх зарчмын дагуу нэхэмжлэгчид учирсан хохирлыг төлөх үндэслэлтэй. Харин маргааны тохиолдлоос үзвэл шүүх нэхэмжлэлийн шаардлагыг хангахгүй байхаар шийдвэрлэсэн. Учир нь тэрээр хуульд зааснаар эзэмшлийн машинуудаа даатгуулсан төдийгүй компанийг өөрийн хувьдаа ашиглаж байгаагүй ба үйл ажиллагааг нь удирдаагүй, хувьцаа эзэмшигч нь бизнес эрхлэхийн тулд корпорацыг өөрийн төлөөлөгч болгон ашиглаж байсан гэж үзэх боломжгүй гэжээ. Энэ нь түүнийг залилах санаа сэдэл зорилготой байгаагүйг нотолно. Иймд Карлтонд хувьд нь хариуцлага хүлээлгэх үндэслэлгүй хэмээн шийдвэрлэжээ.
In re JNS Aviation, LLC	Нэхэмжлэгч нь хариуцагч компани болон түүний хувьцаа эзэмшигч /J. Malcom Shelton, IV, James N. Shelton/	Шүүхээс энэхүү маргааныг шийдвэрлэхдээ АНУ-ын Компанийн Барьцааны тухай Саналын баримт бичиг



	нарыг 1/залилангийн шинжтэй шилжүүлэг хийсэн, 2/эдийн засгийн үүргээ зөрчсөн, 3/залилсан, 4/компанийн хөшгийг цоолох үндэслэлтэй гэж маргасан ба хариуцагчийн зээлээ төлөөгүй үйлдлээс болж нэхэмжлэгч компани дампуурах нөхцөлд хүрсэн гэж тайлбарлажээ.	болон тохиолдлуудад үндэслэн ⁶⁰ хариуцагч нь зээлдэгч мөн байх төдийгүй нэхэмжлэгч хуулийн этгээдээс гадна өөр олон байгууллагаас зээл авсан байна. Энэ нь залилах зорилготой байсан гэж үзэж болох юм. Иймд хариуцагч хуулийн этгээдийн бүх хөрөнгөөр нэхэмжлэгч нарын хохирлыг арилгавал зохино гэж үзэж компанийн хөшгийг цоолон хувьцаа эзэмшигч болох James Shelton-оос залилсан гэж \$947,577.80 гаргуулахаар, J. Malcolm Shelton, and James N. Shelton нар болон хариуцагч компаниас \$868,894.84 гаргуулан нэхэмжлэгчид олгохоор шийдвэрлэжээ.
--	---	---

35. Дээрхээс үзвэл, дэлхийн улсууд компанийн хувьцаа эзэмшигчийн хариуцлагатай холбоотой маргаанд “хөшиг цоолох” ойлголтыг тайлбарлан хэрэглэж шийдвэр гаргахдаа компанийг байгуулсан мөн чанар, хувьцаа эзэмшигчийн санаа зорилго, удирдлагыг хэрэгжүүлсэн этгээдийг түлхүү анхаарч шийдвэрлэдэг байна.

“Компанийн хөшиг цоолох” талаар АНУ-ын туршлага

36. АНУ-ын муж улсуудын хууль нь “компанийн хөшиг цоолох” асуудлаар ялгаатай зохицуулалтуудыг агуулдаг ба дараах байдлаар зохицуулдаг:

Муж улсын нэр	“Компанийн хөшиг цоолох”-д тавигдах шаардлага, шалгуур
Флорида	- Хувьцаа эзэмшигч нь удирдлага хэрэгжүүлсэн байх; - Хувьцаа эзэмшигч нь зохисгүй үйлдэлд оролцсон, үйлдсэн байх.
Аляска	- Салгах тест-Хөшгийг цоолохын тулд хэт их хяналт байсан эсвэл компанийн буруутай үйл ажиллагааг нотлон харуулах ёстой; - Холболтын тест-Шүүхээс хөшгийг цоолохын тулд хэт их хяналт хэрэгжүүлсэн, компанийн хууль бус үйлдлийг хоёуланг нь нотлох ёстой.
Невада	- Компанийн хувьцаа эзэмшигч нь түүнийг төлөөлөн удирдсан байх; - Ашиг сонирхол, өмчлөлийн нэгдмэл байдал байх ёстой бөгөөд нэг нь нөгөөгөөсөө салшгүй холбоотой байх ёстой; - Тусдаа байгууллагын зарчмыг даган мөрдсөн байх, гэвч энэ нь залилан мэхэлсэн, шударга байдлыг зөрчсөн байх.
Нью Йорк	Нью-Йоркт Walkovsky v. Carlton гэх алдартай маргаан байдаг. Тухайн хэргийн шүүх хувьцаа эзэмшигч нь бизнес эрхлэхийн тулд компанийг өөрийн төлөөлөгчөөр ашиглаж байсныг нэхэмжлэгч талаас нотлох шаардлагатай гэж үзжээ. Ингээд компанийн хариуцлагыг хувь хүн хүлээхгүй гэж үзсэн.
	Техас мужид In re JNS Aviation, LLC гэх алдартай маргаан байдаг. Шүүхээс хөшиг цоолох стандартуудаас нэгийг нь хангасан бол хөшиг цоолох тохиолдлыг ашиглаж болно гэж үзжээ. Цаашилбал, хувьцаа эзэмшигч нь залилан мэхлэхийн тулд компанийг ашиглахаар төлөвлөж

⁶⁰ Fifth Circuit opinions of In re Mortgage America Corp., 714 F.2d 1266 (5th Cir. 1983), Matter of S.I. Acquisition, Inc., 817 F.2d 1142 (5th Cir. 1987), and Matter of Educators Group Health Trust, 25 F.3d 1281 (5th Cir. 1994)

Техас	байсан бөгөөд компани нь "үндсэндээ хариуцагчийн хувийн ашиг тусын тулд" байгуулагдсан бол жинхэнэ залилан хийсэн гэж үзэж шүүхээс компанийн хөшгийг цоолж шийдэх болно. Шалгуур: • Компанийн хувьцаа эзэмшигч нь түүнийг төлөөлөн удирдсан байх; • Хуулийн хязгаарлалтаас удаа дараа зайлсхийсэн байх; • Залилан хийсэн байх /залилсан байх/.
-------	--

Оросын Холбооны Улсын эрх зүйн зохицуулалт

37. ОХУ-д Эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаан дахь иргэний нэхэмжлэлийн харьяалал нь эрүүгийн хэргийн харьяаллаар тодорхойлогддог.⁶¹
38. ОХУ-ын хууль зүйн толь бичигт гэм хор гэдгийг иргэний эрх зүйд субъектив эрх буюу сайн талыг багасгах эсвэл хэрэгцээт бүхнийг устгах гэсэн утгаар тодорхойлсон. Гэм хор ба хохирлыг ихэвчлэн ижил утгатай байдлаар хардаг. Харин хохирол болон алдагдлын тухай ойлголтууд нь хоорондоо ялгаатай. Эхний ойлголт нь илүү өргөн хүрээтэй бөгөөд эд хөрөнгийн болон эд хөрөнгийн бус хохирол гэж хуваагддаг. Эд хөрөнгийн хохирол гэдэг нь зардлын хэлбэртэй гэмт хэргийн материаллаг (эдийн засгийн) үр дагавар юм. Эд хөрөнгийн хохирлын мөнгөн дүнг алдагдал гэж нэрлэдэг. Хохирол гэдэг нь гэм хортой ижил утгатай. Эд хөрөнгийн хохирол ба хувийн шинж чанарын хохирол (эрүүл мэнд, ёс суртахууны хохирол) гэж хоёр ангилдаг. Хохирлын мөнгөн дүнг алдагдал гэнэ.
39. Эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааны хүрээнд төрийн үүрэг нь 6 дугаар зүйлд томьёолон заасан гэмт хэргийн хохирогч болох хувь хүн, хуулийн этгээдийн иргэний эрхийг зохих ёсоор хамгаалах явдал юм. ОХУ -ын Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 6 дугаар зүйл нь эд хөрөнгийн хохирол, ёс суртахууны хохирлыг нөхөн төлүүлэх тухай нэхэмжлэлийг шийдвэрлэх замаар хэрэгждэг. Иргэн, хуулийн этгээдийг гэмт хэргийн хохирогч гэж хүлээн зөвшөөрөх, үүний дагуу иргэний нэхэмжлэгчийн хувьд шийдвэр гаргах гол түлхүүр нь "гэм хор" гэсэн ойлголт юм.
40. Эрүүгийн байцаан шийтгэх хуульд "хохирол" гэсэн ойлголтын тодорхойлолтыг тусгаагүй бөгөөд энэ нь тухайн иргэнийг иргэний нэхэмжлэгчээр хүлээн зөвшөөрөх асуудлыг шийдвэрлэхэд зарим хүндрэл учруулдаг ажээ. Гэмт хэргийн улмаас учирсан хохирлыг иргэдийн хувьд бие махбодын, эд хөрөнгө, ёс суртахууны, хуулийн этгээдийн эд хөрөнгийн хохирол, бизнесийн нэр хүндэд хохирол учруулсан гэж хуваадаг. Бодит байдал дээр хохирлыг нөхөн төлүүлэх гэх мэт аргыг эрүүгийн хэрэгт бараг ашигладаггүй бөгөөд ихэнхдээ хулгайлсан эд зүйлээ буцааж өгөх, (заримдаа бодит үнэ цэнийг нь ихээхэн бууруулж) гэмтсэн эд хөрөнгө сэргээн засварлах учирсан хохирлыг нөхөн төлүүлэх гэх мэт арга хэмжээ авдаг байна.

Япон Улсын эрх зүйн зохицуулалт

41. Япон Улсын хаалттай компанийн хувьд 1971 оны 6 дугаар сарын 24-ний өдөр Улсын Дээд Шүүх нэг хувьцаа эзэмшигчтэй хаалттай компанийн дотоод асуудлаар шийдвэр гаргаж байсан. Гуравдагч этгээдтэй холбоотой асуудлын хувьд 1969 оны 2 дугаар сарын 27-ны өдөр Улсын Дээд Шүүхээс анхны "компанийн хөшгийг цоолсон" шийдвэр гаргасан. Тус

⁶¹ ОХУ-ын Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 31 дүгээр зүйлийн 10 дахь хэсэг.

шийдвэрт компани нь 1/компанийн мөн чанарыг санаатайгаар хазайлгасан бол эсхүл 2/компани нь бие даасан бус ердөө хувьцаа эзэмшигчийн өөр нэгэн хувилбар байх тохиолдолд “хөшгийг цоолно” гэж үзжээ.

42. Японы Худалдааны хуулийн 266-3 дугаар зүйлд зааснаар компанийн гүйцэтгэх удирдлага нь өөрийн үүргийг биелүүлэхдээ буруу санаа зорилго, ноцтой хайнга байдал эсхүл худал мэдүүлсэн, компанийн дансыг худал мэдүүлсэн зэргийн улмаас гуравдагч этгээдэд учруулсан хохирлыг хариуцна. Энэ зохицуулалт нь гүйцэтгэх удирдлагын компанийн өмнө хүлээх үүрэгтээ хайнга хандах нь хариуцлага хүлээхэд хангалттай гэсэн маргаан дагуулдаг боловч энэ зохицуулалт нь хаалттай компанитай гэрээ хэлцэл байгуулсан гуравдагч этгээдийг хамгаалахад оршдог. 266-3 дахь энэ зүйл нь компанийн хөшгийг цоолох номлолтой ижил үүрэгтэй юм. Компанид ямар ч үүрэггүй ажлын байр нь нэр төдий гүйцэтгэх удирдлага байсан ч гуравдагч этгээдийн өмнө хүлээх хариуцлагаас чөлөөлөгдөхгүй.

ДӨРӨВ. ШҮҮХИЙН ПРАКТИК

43. 2015 оноос 2021 оныг хүртэлх хугацааны УДШ, НИХДЗШШ-ийн болон сүүлийн 3 жилийн Иргэний хэргийн АШШ-ийн нийт 1790 шийдвэрээс үзэхэд, банк, зээлийн гэрээтэй холбоотой эрүүгийн шийтгэх тогтоолоор учирсан хохирлоо иргэний журмаар нэхэмжилж байгаа тохиолдол гараагүй байна.
44. Харин насанд хүрээгүй этгээд хүний эрүүл мэндэд учирсан гэм хорыг шийдвэрлэсэн⁶², төрийн албан хаагчийн учруулсан хохирлыг төрийн байгууллага ажилтнаас нөхөн нэхэмжилсэн⁶³, ажилтны байгууллагад учруулсан хохирол⁶⁴, 16 нас хүрээгүй хүний эрүүл мэндэд эмнэлгийн байгууллагын буруутай үйл ажиллагаанаас учирсан гэм хор⁶⁵, 16 нас хүрээгүй хүний эрүүл мэндэд учирсан хохирол⁶⁶, хохирогч нас барснаас учирсан гэм хор⁶⁷, зам тээврийн ослын гэмт хэрэгтэй холбоотой хөөн хэлэлцэх хугацаа дууссан гэж үзсэн боловч иргэний журмаар эд хөрөнгөд учирсан хохирлоо нэхэмжилсэн⁶⁸, бусдын эд хөрөнгийг санаатайгаар устгах, гэмтээх гэмт хэргийн улмаас учирсан хохирлыг нэхэмжилсэн⁶⁹, тээврийн хэрэгсэл ашиглалтын явцад хүний эрүүл мэндэд хохирол учруулсан⁷⁰, хүний эрүүл мэндэд хөнгөн хохирол учруулсан нь гэмт хэргийн шинжтэй гэж үзэж шийтгэх тогтоол гарсан ба холбогдох зардлыг иргэний журмаар нэхэмжилсэн⁷¹, зам тээврийн ослын улмаас тээврийн хэрэгсэлд учирсан хохирлыг гаргуулах⁷², замын хөдөлгөөний дүрэм зөрчсөнөөс тээврийн хэрэгсэлд хохирол учруулсан тухай⁷³, байгууллагын захирлаар ажиллаж байсан этгээд эрүүгийн хөрөнгө завших гэмт хэрэгт гэм

⁶² УДШ-ийн 2015 оны 11 сарын 05-ны өдрийн 912 дугаар тогтоол.

⁶³ УДШ-ийн 2018 оны 11 сарын 27-ны өдрийн 001/ХТ2018/01710 дугаар тогтоол.

⁶⁴ УДШ-ийн 2018 оны 05 сарын 25-ны өдрийн 001/ХТ2018/00860 дугаар тогтоол.

⁶⁵ УДШ-ийн 2018 оны 12 сарын 13-ны өдрийн 001/ХТ2018/01837 дугаар тогтоол.

⁶⁶ УДШ-ийн 2018 оны 05 сарын 15-ны өдрийн 001/ХТ2018/00777 дугаар тогтоол.

⁶⁷ УДШ-ийн 2018 оны 12 сарын 07-ны өдрийн 001/ХТ2018/01805 дугаар тогтоол, УДШ-ийн 2018 оны 02 сарын 08-ны өдрийн 001/ХТ2018/00239 дугаар тогтоол.

⁶⁸ УДШ-ийн 2020 оны 04 сарын 14-ний өдрийн 001/ХТ2020/00183 дугаар тогтоол.

⁶⁹ УДШ-ийн 2021 оны 03 сарын 16-ны өдрийн 001/ХТ2021/00212 дугаар тогтоол.

⁷⁰ Хан-Уул дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2019 оны 05 сарын 13-ны өдрийн 183/ШШ2019/01159 дугаар шийдвэр.

⁷¹ Говь-Алтай аймаг дахь сум дундын Иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2021 оны 1 сарын 8-ны өдрийн 133/ШШ221/00029 дугаар шийдвэр.

⁷² Орхон аймаг дахь сум дундын Иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2021 оны 1 сарын 21-ний өдрийн 142/ШШ/2021/00106 дугаар шийдвэр.

⁷³ Баянгол дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2019 оны 05 сарын 22-ны өдрийн 1515 дугаар шийдвэр.



буруутай нь тогтоогдсон тул гэм буруугаа хүлээн зөвшөөрсөн этгээдээс байгууллагад учирсан хохирлыг нэхэмжилсэн ⁷⁴, зээлийн гэрээний үүргээ гүйцэтгээгүйн улмаас хариуцагчийг эрүүгийн залилах гэмт хэрэг үйлдсэн гэж тогтоосон боловч хөөн хэлэлцэх хугацаа дууссан тул эрүүгийн хариуцлага хүлээлгэх үндэслэлгүй боловч иргэний журмаар гаргасан нэхэмжлэлийн зарим хэсгийг хангаж⁷⁵ шийдвэрлэсэн шийдвэрүүд байна.

⁷⁴ Баянзүрх дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2019 оны 06 сарын 04-ний өдрийн 1666 дугаар шийдвэр.

⁷⁵ Хан-Уул дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2019 оны 04 сарын 19-ний өдрийн 183/ШШ2019/00935 дугаар шийдвэр.



ТАВ. ДҮГНЭЛТ

45. Гэмт хэргийн улмаас учирсан хохирлыг эрүүгийн хэрэгтэй нь хамт шийдвэрлэх боломжтой. Тухайн үед тодорхойлох боломжгүй хохирол эсхүл эрүүгийн шүүхээс хохирогчийг иргэний журмаар хохирлоо нэхэмжилж болох талаар дурдсан тохиолдолд ИХ-ийн гэм хорын эрх зүйн зохицуулалтыг үндэслэн нэхэмжлэл гаргадаг. Гэм хорыг арилгах үүрэг нь гэм хор учруулсан этгээдэд үүсэх бөгөөд гэмт хэргийн улмаас учирсан хохиролд ч мөн адил гэм буруутай этгээд хохирлыг хариуцан арилгадаг шүүхийн практик байна.
46. Компанийн хувьцаа эзэмшигчийн хариуцлагатай холбоотой онолын хувьд үндсэн гурван ойлголт байна. Энэхүү онолын гурван төрлөөс түгээмэл хэрэглэгддэг компанийн эрх зүйн зарчим болж тогтсон нь компанийн *хязгаарлагдмал хариуцлагын* онол юм. Монгол Улсын эрх зүйн зохицуулалтын хувьд Компанийн тухай хуулийн 9.3, 9.5 дугаар зүйлүүдэд компанийн хязгаарлагдмал хариуцлага болон онцгой тохиолдол /компанийн хувь тэнцүүлсэн хариуцлага/ тусгагдсан гэж үзэж болохоор байна.
47. Шүүхийн практикийн хувьд шүүхийн шийдвэрийн цахим сангаас банкны зээлийн гэрээтэй холбоотой гэмт хэргийн улмаас учирсан хохирлыг иргэний журмаар нэхэмжилсэн тохиолдлоос 2015-2021 оны хооронд хайхад шүүлт хийхэд олдоогүй. Харин компанийн хувьцаа эзэмшигчийн хариуцлага хүлээх хязгаартай холбоотой ялгаатай практик ажиглагдлаа. Гэмт хэргийн улмаас учирсан хохирлыг иргэний журмаар нэхэмжилсэн маргааныг шүүхээр шийдвэрлүүлсэн тохиолдлын дийлэнх нь эд хөрөнгөд учирсан гэм хор, 16 нас хүрээгүй хүний учруулсан, бусдын эрүүл мэндэд учирсан гэм хор, хохирогч нас барснаас учирсан, ослын улмаас учирсан гэм хор байлаа.
48. Компанийн хувьцаа эзэмшигчийн хариуцлагатай холбоотой гадаад улсуудын туршлагаас авч үзвэл АНУ-ын онцлох хоёр маргаан байсан ба нэг тохиолдолд нь компанийн иргэнд учруулсан хохирлыг хувьцаа эзэмшигч нөхөн төлөхгүй гэж, Англи улсын хувьд компанийн эрх зүйд чухалд тооцогддог “*компанийн хөшгийг цоолох*” талаар тайлбарласан Salomon v Salomon маргааныг хамгийн анх 1897 онд шийдвэрлэж байжээ. Харин Япон улсын эрх зүйн зохицуулалтын хувьд онцлог гэж хэлж болохоор буюу компанийн гүйцэтгэх удирдлага, хувьцаа эзэмшигч нь өөрийн буруутай үйлдэлд гуравдагч этгээдийн өмнө хариуцлага хүлээдэг эрх зүйн зохицуулалт байна.
49. Харин манай судалгаатай холбогдох маргааны тохиолдолтой адил хувьцаа эзэмшигчийн буруутай үйлдлийн улмаас учруулсан хохирлыг компаниас нэхэмжилж арилгуулсан тохиолдол судалгааны хүрээнд ашигласан эх сурвалжид тусгагдаагүй байна.

ЗУРГАА. ЭХ СУРВАЛЖ

Хууль тогтоомж:

1. Иргэний хууль, 2002.
2. Иргэний хуулийн 44, 45, 46 дугаар бүлэг, банк, эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, төлбөр тооцоо, зээлийн үйл ажиллагааны тухай хуулийн зарим зүйл, заалтыг тайбарлах тухай, УДШ-ийн 53 дугаар тогтоол.
3. ОХУ-ын Эрүүгийн байцаан шийтгэх хууль, 2002.
4. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль, 2017.
5. Япон улсын Худалдааны хууль.

Ном, сэтгүүл:

Монгол хэлээр:

1. М.Ванчигмаа, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаан дахь иргэний нэхэмжлэл. 2019.
2. Г.Давааням, Компани, арилжааны эрх зүйн тулгамдсан асуудлууд, 2020.
3. Г.Давааням, Морал хазардын асуудлаас үүдэх толгой компанийн хариуцлага, Хязгаарлагдмал хариуцлагын үр ашгийн талаар, 2020.
4. Т.Мөнхжаргал, Иргэний эрх зүй үүргийн тусгай төрөл. 1998.
5. Монгол Улсын иргэний хуулийн тайлбар (Гэрээний бус үүрэг) IV. 2016 он.

Гадаад хэлээр:

1. Andrew Hicks & S.H. Goo, Company law (6th edition), 102-104 (2008).
2. Mitchell, W, Early Forms of Partnership, 186 (1907).

Шүүхийн шийдвэрүүд:

Анхан шатны шүүхийн шийдвэр:

1. Хан-Уул дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2019 оны 05 сарын 13-ны өдрийн 183/ШШ2019/01159 дугаар шийдвэр.
2. Хан-Уул дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2019 оны 04 сарын 19-ны өдрийн 183/ШШ2019/00935 дугаар шийдвэр.
3. Хан-Уул дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2020 оны 04 дүгээр сарын 30-ны өдрийн 183/ШШ2020/01129 дугаар шийдвэр.
4. Говь-Алтай аймаг дахь сум дундын Иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2021 оны 1 сарын 8-ны өдрийн 133/ШШ221/00029 дугаар шийдвэр.
5. Орхон аймаг дахь сум дундын Иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2021 оны 1 сарын 21-ний өдрийн 142/ШШ/2021/00106 дугаар шийдвэр.
6. Баянгол дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2019 оны 05 сарын 22-ны өдрийн 1515 дугаар шийдвэр.
7. Баянзүрх дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2019 оны 06 сарын 04-ны өдрийн 1666 дугаар шийдвэр.

Давж заалдах шатны шүүхийн шийдвэр:

8. НИХДЗШШ-ийн 2020 оны 08 дугаар сарын 21-ний өдрийн 01808 дугаар магадлал.
9. Говь-Алтай аймгийн Эрүү, Иргэний давж заалдах шатны шүүхийн 2018 оны 06 сарын 21-ний өдрийн 15 дугаар магадлал.



10. Дорнод Аймгийн Эрүү, Иргэний давж заалдах шатны шүүхийн 2020 оны 09 дүгээр сарын 21-ний өдрийн 201/МА2020/0025 дугаар магадлал.
11. Орхон аймгийн Иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн 2019 оны 05 дугаар сарын 21-ний өдрийн 71 дугаар магадлал.

Хяналтын шатны шүүхийн шийдвэр:

12. УДШ-ийн 2018 оны 12 сарын 07-ны өдрийн 001/ХТ2018/01805 дугаар тогтоол.
13. УДШ-ийн 2018 оны 02 сарын 08-ны өдрийн 001/ХТ2018/00239 дугаартай тогтоол.
14. УДШ-ийн 2015 оны 11 сарын 05-ны өдрийн 912 дугаар тогтоол.
15. УДШ-ийн 2018 оны 11 сарын 27-ны өдрийн 001/ХТ2018/01710 дугаар тогтоол.
16. УДШ-ийн 2018 оны 05 сарын 25-ны өдрийн 001/ХТ2018/00860 дугаар тогтоол.
17. УДШ-ийн 2018 оны 12 сарын 13-ны өдрийн 001/ХТ2018/01837 дугаар тогтоол.
18. УДШ-ийн 2018 оны 05 сарын 15-ны өдрийн 001/ХТ2018/00777 дугаар тогтоол.
19. УДШ-ийн 2018 оны 12 сарын 07-ны өдрийн 001/ХТ2018/01805 дугаар тогтоол.
20. УДШ-ийн 2018 оны 02 сарын 08-ны өдрийн 001/ХТ2018/00239 дугаар тогтоол.
21. УДШ-ийн 2020 оны 04 сарын 14-ний өдрийн 001/ХТ2020/00183 дугаар тогтоол.
22. УДШ-ийн 2021 оны 03 сарын 16-ны өдрийн 001/ХТ2021/00212 дугаар тогтоол.

Гадаад шүүхийн шийдвэрүүд:

1. <https://www.lawteacher.net/cases/salomon-v-salomon.php>
2. <https://www.lawteacher.net/cases/dhn-v-tower-hamlets.php>
3. <https://www.lawteacher.net/free-law-essays/company-law/lifting-the-veil-separation-of-the-personality-company-law-essay.php>
4. <https://www.lexisnexis.com/community/casebrief/p/casebrief-walkovszky-v-carlton>
5. <https://casetext.com/case/in-re-jns-aviation-4?cf=chljschltk=&pmd=JH02ywlyl&ec=EUtrnpsmQ9I57YVv33nNwb4jfhTId4-1634904791-0-ggNtZGzNAmWjcnBszQnl>

Цахим эх сурвалж:

1. <https://www.companydebt.com/shareholders-liaable-company-debts/>
2. Gordon G. Sollars, An Appraisal of Shareholder Proportional Liability, <https://link.springer.com/article/10.1023/A:1010768824610>
3. Shareholder Liability: Piercing the Corporate Veil <https://www.svlaw.ca/blog/details/item/shareholder-liability-piercing-the-corporate-veil>
4. Piercing the Corporate Veil, https://www.law.cornell.edu/wex/piercing_the_corporate_veil
5. Are shareholders of the corporation personally liable for obligations of the corporation? https://thebusinessprofessor.com/en_US/business-governance/shareholder-personal-liability-for-corporate-obligations